

ЭРТНИЙ СУДАР ДАХЬ ЧИНДАРУУ ЦАГААНЫ ЭМИЙГ ТАТУУЛАХ АРГЫН АГУУЛГА, МӨН ЧАНАРЫГ ТОДРУУЛАХ НЬ

*Батмөнх Байгальчимэг¹, Болд Жавхлан², Баттогтох Гэрэлмаа³,
Цэрэндорж Дагвадорж³, Мөнхдорж Дармаа³, Шарав Болд^{1*}*

¹Уламжлалт Анагаах Ухааны Тэнхим, Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль, Улаанбаатар
хот, Монгол Улс

²Graduate School of Medicine, Gunma University, Japan

³Уламжлалт Анагаах Ухааны Сургууль, “Ач” Анагаах Ухааны Их Сургууль, Улаанбаатар
хот, Монгол Улс

*цахим хаяг: boldshrv@gmail.com

A STUDY ON THE ESSENCE AND MEANING OF THE NASAL IMMUNIZATION METHOD OF THE WHITE ASH MEDICINE IN AN ANCIENT TEXT

*Baigalichimeg Batmunkh¹, Javkhlan Bold², Gerelmaa Battogtokh³,
Dagvadorj Tserendorj³, Darmaa Munkhdorj³, Bold Sharav^{1*}*

¹Department of Traditional Medicine, Mongolian University of
Pharmaceutical Sciences, Ulaanbaatar, Mongolia,

²Graduate School of Medicine, Gunma University, Japan

³School of Traditional Medicine, Ach Medical University, Ulaanbaatar, Mongolia

*email: boldshrv@gmail.com

Abstract

Introduction: The text “Secret Medicine Recipes of Important Matters” represents a unique heritage that embodies the theories and concepts of traditional Mongolian medicine, particularly as a documentary source of medicinal composition. Through this work, it is important to examine the terminology, theoretical and methodological concepts, and characteristics of medical works written in Mongolian script within the field of traditional Mongolian medicine.

To conduct a study of the final words of the second volume of the “Secret Medicine Recipes for Important Matters” and to compare and analyze the original text, including some outdated terms and content.

Methods: The second volume of the book “Secret Medicine Recipes for Important Matters” is a Mongolian manuscript. The book measures 22.7x22.3 cm and contains 111 pages. It is covered with yellow silk featuring a floral pattern and is bound with four holes using twisted brownish-yellow thread. The text is written on coarse paper with red lines. Methods of textual analysis for ancient books and translated methods were used in the study.

Conclusion: The second volume of the “Secret Medicine Recipes for Important Matters” contains a description of the nasal immunization method of the white ash medicine used for disease prevention. The method involves administering the substance through the nose to regulate sputum, and from a modern perspective, it can be interpreted as a live vaccination. The most optimal version of this method was created by Tsakhar Geshe Luvsanchultem and written in his work, and later used as an injection for the three Gobi Gurvan Saikhan’s Sharav maaramba.

Keywords: Traditional medicine, Mongolian medicine, nasal immunization, white ash, ash medicine

Үндэслэл

Монголын анагаах ухаан 5000 жилийн өмнөөс үүсэн бүрэлдэж хөгжих явцдаа Энэтхэг, Төвөд, Хятад, Исламын анагаах ухааны ололт, амжилтууд, манж, хятад, төвөд, эртний орос хэлнээс орчуулсан анагаах ухааны номын онол, практикийн мэдлэг болон гарын авлагыг өөрийн анагаах ухааны онол, мэдлэгтэйгээ уялдуулан нэгтгэмэл анагаах ухааны тогтолцоог бүрэлдүүлж, цаашлаад бусад улс, гүрнүүдэд Монголын уламжлалт анагаах ухааныг дэлгэрүүлэн, хөгжүүлж байсан нь өнөө цагийн археологийн олдворууд болон сурвалж бичгийн баримтуудаар нотлогдон тодорсоор байна.^{1,2,3} Сурвалж бичгийн хувьд VIII Богдын номын сангаас Судар бичгийн хүрээлэнгийн номын хөмрөгт 1924 онд шилжүүлсэн монгол гар бичмэл 1223 номоос олон ботитой номоос тус бүр нэг нэг хувийг төлөөлүүлэн, мөн цор ганц хувь номыг сонгох замаар 78 гар бичмэл ном авчээ. Энэ 78 гар бичмэл номын дотор анагаах ухааны холбогдолтой 9 ном байгаагийн нэг нь “Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” хэмээх гар бичмэл орчуулгын ном юм. Энэхүү ном нь тэргүүн болон хоёрдугаар гэсэн 2 тусдаа дэвтэртэй, урьд өмнө нь судлагдаж байгаагүйн дээр Монголын уламжлалт анагаах ухааны онол, ойлголтыг шингээсэн өв, тэр дундаа эм найрлага судлалын баримтат сурвалж гэдгээрээ онцлогтой.⁴ “Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” хэмээх энэхүү бүтээлээр дамжуулан Монголын уламжлалт анагаах ухаан судлалд монгол бичгээр бичигдсэн анагаах ухааны бүтээл туурвилын нэр томьёо, онол арга зүйн ойлголт, онцлогийг судлах нь чухал ач холбогдолтой байна.

Судалгааны ажлын зорилго

“Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” номын хоёрдугаар дэвтрийн төгсгөлийн үгийн судалгааг хийж чиндаруу цагаан болон зарим хуучирсан нэр томьёо, агуулгыг харьцуулан шинжлэх.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга

- Судалгааны хэрэглэгдэхүүн

“Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” номын хоёрдугаар дэвтэр нь VIII Богд хааны номын сангаас 1924 онд Судар бичгийн хүрээлэнгийн номын санд ирсэн 1223 гар бичмэл номын нэг. Одоо Үндэсний номын санд хадгалагдаж байна. Бид “Монголын уламжлалт анагаах ухааны

108 боть” бүтээлийг хэвлүүлэхийн тулд МУ-ын Соёлын Яамнаас бичгээр зөвшөөрөл авч улмаар төслийн удирдагч академич Ш.Болд, Үндэсний номын сангийн захирал Б.Ичинхорлоо нар гэрээ хийж, уг гэрээний дагуу энэ номын хуулбарыг авч судалгаанд ашигласан. Уг номын хэмжээ нь 22.7х22.3 см, 111 нүүр, цэцгэн хээтэй шар торгон хавтастай, эрчилсэн, хүрэн шаргал утсаар 4 цоолон үдэж нуруулдсан. Улаан шугамтай, барласан муутуу цаасан дээр бичсэн. Бичгийн хэв нь тогтуун, монгол бичиг (эмийн нэршил манжаар бичигдсэн)-ээр бичигдсэн гар бичмэл бүтээл юм. Түүнчлэн Цахар гэвш Лувсанчүлтэм, Лувсансамдүвням болон Ш.Болд, Б.Жавхлан нарын халдварт өвчний талаар туурвисан ном судруудыг харьцуулах үндсэн хэрэглэгдэхүүн болгон ашиглав. Үүнд:

1. Лувсансамдүвням. Цахар гэвшийн намтар. Монгол бичгээс хөрвүүлж, удиртгал тайлбар бичсэн Д.Цэрэнсодном, Д.Наранцэцэг. Ариутган шүүсэн Ш.Бира. УБ, 2010. 638 х.
2. Лувсанчүлтэм. Басамын тосон эм ба таван рашааны дэвтээлэг тэргүүтнийг хийх ёс оршвой. Гар бичмэл монгол судар.
3. Ш.Болд, Б.Жавхлан нарын “Хүннүгээс Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш нарын цадиг, бүтээл.” УБ, 2020, 325 х.

Судалгааны ажилд хэрэглэсэн арга

“Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” гар бичмэл номыг судлахдаа бид хөрвүүлэх арга, эх бичиг, сурвалж судлалын аргыг ашиглав.

- Хөрвүүлэх арга

Хөрвүүлэх аргыг дотор нь үгчлэн хөрвүүлэх, галиглан хөрвүүлэх, утгачлан хөрвүүлэх, болон ерөнхий агуулгаар хөрвүүлэх гэж хуваадаг. Бид “Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” гар бичмэл номын хоёрдугаар дэвтрийн монгол бичгийн эхийг кирилл үсэгт хөрвүүлэхдээ үгчлэн хөрвүүлэх аргыг голчлон ашиглаж, эмийн нэршлийг манжаар бичсэнийг буулгахдаа галиглан хөрвүүлэв.

- Эх бичиг, сурвалж судлалын арга

Эх бичиг, сурвалж судлалын арга нь сурвалж бичгийн эх, нэр, зохиогч, газар орон, онцлог, агуулга, тайлбар, харьцуулалт, хөрвүүлэг, нэрийн хэлхээ зэргийг нэгэн дор хамтатган судалдаг. Судалгааны уг арга хэлбэрээрээ НТӨ III зууны

үед эртний Египетын Александрын номын сангийн эрдэмтдийн дунд анх үүссэн гэж үздэг. Орчин үед (XIX зуун) Германы түүхч Леопольд фон Ранке эх сурвалжийг шинжлэх ухааны үндэстэй шүүмжлэх (source criticism) аргыг боловсронгуй болгосноор сурвалж бичиг судлал бие даасан шинжлэх ухааны арга зүй болон төлөвшжээ. Бид энэ аргаар тус гар бичмэл номын төгсгөлийн үгийг хөрвүүлэн, задлан шинжилж, зарим нэр томъёог шинжлэх, галиглах, үгийн тайлбар хийхэд ашиглалаа.

Судалгааны ажлын үр дүн

1. Чиндаруу цагаан эмтэй холбоотой хуучирсан нэр томъёоны тайлбар

“Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” гар бичмэл номыг хөрвүүлж, галиглан, зарим тохиолдолд утгачлан хөрвүүлэх явцад хуучирсан нэр томъёонууд нилээд тохиолдсон ба тэдгээрийн утгыг бид судалгаагаар дараах байдлаар олж тогтоов (Хүснэгт 1).

Table 1. “Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” гар бичмэл дэх хуучирсан нэр томьёо, түүний тайлбар

“Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” гар бичмэл дэх хуучирсан нэр томьёоны түүвэр	Хуучирсан нэр томьёоны тайлбар
- Чиндаруу цагаан - Егзөр - Мигзэм - Ядам - Сахиус - Чиндаруу цагааны хогжруу - Сандаг - Харын хятад - Харын - Жишигсэн - По - Навчны цуудас - Маань бум - Түүнээс өглөгийн эзний мөр алин болох дор хятад зүүний үзүүрээр цус үл гарахын төдий хусаад рашаан усыг өчүүхэн хиймүй -Хатсаны сүүлд даавуу цагаан тэргүүтнээр ороохуй дор үйлд - Эдмэрдэх - Дүүдээ - Бумсан	- Цэцэг өвчнийг цээрлэн нэрлэсэн нэр - Бурхны шашны гүн ухааны дэг урсгал, бурхны номыг гүн бясалгаж, шидийг олсон их хүн. - Залбирал соёрхол агуулсан, судар тарнийн номын хүч чадал, гүн гүнзгий увдис бүхнийг хураасан, Гэлүг сургуулийг үндэслэгч Богд Зонхов ламын залбирал уншлага. - Судар, тарнийн номлолд гол шүтээн болгон бясалгах, шид бүтээл хайрлах бурхад - Сахиус гэдэг нь бурхан шашины уламжлалд гай гамшиг, өвчин зовлон, ад зэтгэрээс хамгаалж, аз жаргал, амжилтыг дууддаг эсвэл хамгаалагч шүтээнийг хэлнэ. - Цагаан цэцэг буюу бодоо өвчний цэврүү - Нууцын эзэн гэсэн үг байж магадгүй - Жанаг гэсэн үгийн орчуулга бололтой - Хар бодоо өвчний товч нэр - Жишүү болгох, гажих, таших - Манж хэлний "р" болон "о" (ᠷ) үсэг нийлж бүтсэн гадаад үгийг тэмдэглэдэг манж авиа. Энэхүү бичвэрт чухам юуны талаар өгүүлснийг олж чадсангүй. - Юмнаас цуулж авсан эдийн ширхэг, хэсэг. - Маань бум гэдэг нь “Ум мани бад мэ хум” хэмээх Жанрайсиг бурхны зүрхэн тарнийг 100,000 (нэг зуун мянга) удаа тоолж уншихыг хэлнэ. - Бодоо өвчний тарилга (вакцин)-ыг хийхдээ арьсан доорх зүү ашиглаагүй харин хурц иртэй хятад зүүгээр цус гарах төдий зүсээд уг зүссэн хэсэгтээ бодоогийн бодисыг оруулна гэдгийг хэлжээ. - Тарилгаа хийсний дараа цэвэр цагаан давуугаар боолт хийнэ гэсэн үг - Зөөлөн эдлэлийн элэгдэж хэврэгших, сэмэрч эхлэхтэй зүйрлэн хэлжээ. - Түгдрэх, ямар нэгэн саад учрах үзэгдлээс бусад - ... Буман сангийн хураангуй гэдэг судар болов уу хэмээн таамаглав.

Судалгааны явцад бид “Чиндаруу цагаан” гэдэг үгийн утгыг анагаах ухааны хувьд анх удаа олж тогтоосон. Ингэж бичих гол үндэслэл нь MongolMed, SCOPUS, WoS, Монгол Улсын Үндэсний номын санд хадгалагдаж байгаа анагаах ухаан, хэл шинжлэлтэй холбоотой сэтгүүлүүдээс хайлт хийж үзээд энэ үгийг тайлбарласан ямар нэгэн тайлбар бүхий судалгааны өгүүлэл олоогүйд оршиж байна. Энэ үг нь хэл шинжлэлийн хувьд хуучирсан үг бөгөөд зарим тохиолдолд бэрх үг ч гэж үзэх боломжтой юм. Гол утга нь цэцэг өвчин, бодоо, орчин цагийн анагаах ухааны ойлголтоор **Оспа** (Smallpox, үүсгэгч нь *Variola virus*) өвчнийг цээрлэн нэрлэсэн утгатай юм. Нарийн ялган үзвэл чиндаруу гэдэг нь чандруу гэсэн гал түймэр, ямар нэгэн зүйлийг шатаахад гарсан үнс, нурам, эсвэл үнс нурам мэт болсон зүйлийг хэлдэг байна.

Түүнчлэн судалгааны явцад манж хэлний «р» болон «о» (ᠷ) үсэг нийлж бүтсэн гадаад үгийг тэмдэглэдэг манж авианы бичвэрт чухам юуны талаар өгүүлснийг олж чадсангүй. Учир нь одоогоор олдоод байгаа Манж хэлний тайлбар тольд алга байв.

2. Чиндаруу цагаан эмтэй холбоотой мэдээ баримтыг шинжлэх нь

Цахар гэвш Лувсанчүлтэмийн бодоо өвчинд болгох ерөндгийн талаар академич П.Нямдаваа, Ш.Болд нар анх удаа судалгаа хийж өгүүлэл нийтлүүлсэн.⁵ Тухайлбал Өрнө дахинаа, түүгээр уламжлан бид ч одоо болтол мөрдсөөр яваа номлолоор бол үхрийн цэцгийн цэврүүний шингэнийг хүний бодоогоос сэргийлэхээр хэрэглэсэн тухайгаа 1798 онд нийтлүүлсэн Английн эмч Эдуард Женнерийг халдварт өвчнөөс сэргийлэх ерөндгийг анх боловсруулсан судлаач хэмээн тооцдог билээ.⁶ Тэгтэл монгол оточ Лувсанчүлтэм бодоогоос сэргийлэх ерөндөг боловсруулах аргыг бичиглэсэн “Тэнгэрийн цагаан цэцэг тарих, эм найруулах ёсон хийгээд татах тэргүүтний бичиг” хэмээх бэсрэг бүтээлээ Э.Женнерээс 13 жилийн өмнө буюу 1785 онд нийтлүүлжээ хэмээсэн байна.⁷ Үүний дараа Ш.Болд, Б.Жавхлан нар “Хүннүгээс Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш нарын цадиг, бүтээл” бүтээлдээ:

Шарав маарамба Цахар гэвшийн «Тэнгэрийн цагаан цэцэг тарих, эм найруулах ёсон хийгээд татах

тэргүүтний бичиг» номын ёс, өөрийн туршлагадаа дулдуйдан бодоо өвчинд болгодог ерөндөг тарьдаг байв. Энэ өгүүлбэр нь “Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” гар бичмэл номын доторх лам дээд гурвын нигүүлсэнгүйгээр адистадлан чиндаруу цагааны эмийг татуулахуй дор орон байшинг арчин цэвэрлэж үйлдээд чухаг дээдийн шүтээнийг бэлтгэж, тахил, балин ариутгалыг бэлтгээд, эм хийгээд өглөгийн эзэн бээр хувцас ариуныг өмсөх хийгээд түүнд оршсон нугууд бээр тамхи татах тэргүүтэн ариун бусыг тэвчих бөгөөд ариун цэвэр хийгээд шүтэн барилдлага сайныг эрхэмлэхүй дор үйлдээд бүтээгч бээр ламын өгзөрийг бясалгаснаас мигзэм юу зохистойг урих бөгөөд соёрхолыг тавина” гэдгийг дэлгэрүүлэн тайлбарласан утгатай дүйж байна. Цаашлаад уг номонд ерөндөг тарих гэрийг хэрхэн барихыг зааж засуулаад дэвсгээс номын хүчээр ариусгасан чулуу ачуулж довжоог нь хийлгэсэн гэдэг. Чандмалж барьсан гурван гэр байх. Оройн гэрт маарамба өөрөө заларч цагаан бурхнаар болоогүй хүүхдэд өвчнийг номхотгон танг татуулдаг байж. Гэхдээ охидын зүүн, хөвгүүдийн баруун хамраар татуулаад толгой дээгүүр нь битүү дээл нөмрүүлж зүүн баруун гэрт нь аваачиж хэвтүүлдэг. Тав, долоо хоногийн дараа хүүхдүүд бүлээрч ганц хоёр тууралт гарна. Тав тогтоод ирмэгц маарамба өөрөө үзэж тавнаас ховхлон дараа жилд хэрэглэх тангийн найрлаганд оруулахаар авдаг байсан. Энэ гурван гэрээс нилээн зайдуу нэг жижгэвтэр гэрт хүүхдийн хоол цай хийж, зөөж өгдөг байсан гэжээ.⁸

Гэтэл “Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” гар бичмэл номын төгсгөлийн үгэнд: Тан той үрэл хийгээд жадонг үрэл тэргүүтэн аль олдсон хийгээд чиндаруу цагааны хогжрууг шүтүүлэн агуулсны дээр гиван хийгээд сандаг найруулмуу. Тэр ч гиван 7 хувь, жуган 2 хувь, гүргэм 4 хувь, задь, лиш, сүгмэл, гагол дөрөв хувь нижгээд нижгээд хогжруу 9 хувь хэмжсэний дээр адистадтай үрлийг хольж талхлан үйлдээд өглөгийн эзнийг угаан үйлдэх тэргүүтэн ариун цэвэр лугаа төгсөхийн үүднээс лам дээд гурав, ер хийгээд ядам номыг тэтгэгч нугууд дор соёрхолыг талбих бөгөөд хөвгүүн дор хамрын нүх зүүн хийгээд хүүхэн дор хамрын нүх баруун дор татуулан орших ану лам дээдсийн зан журам болой гэсэн нь энэ арга Цахар

гэвшийн Лувсанчүлтэм болон Шарав маарамбын аргын уламжлал гэж үзэх үндэстэй байна.

“Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” гар бичмэл номонд чиндаруу цагааны хогжрууг шүтүүлэн агуулсны дээр гиван хийгээд сандаг найруулмуй. Тэр ч гиван 7 хувь, жуган 2 хувь, гүргэм 4 хувь, задь, лиш, сүгмэл, гагол 4 хувь нижгээд нижгээд хогжруу 9 хувь хэмжсэний дээр адистадтай үрлийг хольж талхлан гэж бичсэн нь Цахар гэвш “...гүвдрүүний хуурсан цагаан хальсыг ховхлон авч дээр нь үхрийн гиван, 6 сайны найрлагыг нэмнэ. Тухайлбал, гиван 7 хувь, жуган 2 хувь, гүргэм 4 хувь, задь, лиш, сүгмэл болон гагол тус бүр 4 хувь. Гүвдрүүний хуурч унасан хальсыг 9 хувийн хэмжээгээр нэмээд адистэд бүхий үрэлтэй хольж талх болгон үйлд⁹ гэдэгтэй яг тохирч байна. Иймээс бод өвчнөөс сэргийлэх, хамарт татаж (цацаж) хэрэглэх, номхотгосон амьд вакцин анх бүтээсэн Цахар гэвш Лувсанчүлтэмийн бүтээл үнэ цэнээ одоо ч алдаагүйгээр барахгүй өөрөөс хойш Монголын сүүлчийн хаан, 8 дугаар Богд Жавзандамбын үед ч орц найрлага нь өөрчлөгдөхгүйгээр хэрэглэгдэж байжээ.

Чухамдаа академич П.Нямдаваа, Ш.Болд нарын Өрнийн анагаах ухаанд бол амьтны өндөр хоруу чанартай нянг физик, химийн аргаар нөлөөлөн номхотгож болдгийг Францын нэрт эрдэмтэн Луй Пастер 1880 онд буюу Цахар гэвш Лувсанчүлтэм цагаан цэцгийн амьд, сулруулсан вакцин хийх тухай бүтээлээ туурвиснаас хойш бараг 100 жилийн дараа л анх нийтлүүлжээ¹⁰ гэж бичсэн нь маш чухал дүгнэлт гэж үзэж байна. Үүний зэрэгцээ энэ хоёр эрдэмтэн бодоор өвчилсөн хүний цэврүүний таванд байгаа өндөр хоруу чанартай вирусыг номхотгоход ашигласан эмт бодис бүрийг нэг бүрчлэн нарийвчлан судлах нь вакцин номхотгоход болон дархлааг хүчжүүлэхэд ашиглах өрнийн анагаах ухаанд шинэ, монголын анагаах ухаанд мартагдсан бодис, технологийг нээн олоход ч хүргэж болох нигууртай юм гэж алсын хараатай хэлжээ.

Цахар гэвш Лувсанчүлтэм “Тэнгэрийн цагаан цэцэг тарих, эм найруулах ёсон хийгээд татах тэргүүтний бичиг”, VIII Богд хааны номын сангаас олдсон “Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” номын хоёрдугаар дэвтрийн

төгсгөлийн үгэнд байгаа бодоо өвчинд болгох ерөндгийг хэрхэн хийх, хэрхэн татуулах, түүний бэлтгэл, өвчтөнийг суулгах гэрийг барих газар, зай хэмжээг хамгийн тодорхой бичсэн бүтээл нь Ш.Болд, Б.Жавхлан нарын “Хүннүгээс Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш нарын цади, бүтээл” дэх Говь гурван сайхны алдарт маарамба Шаравын намтар¹¹ болох нь тодорхой байна.

Хэлцэмж

“Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” гар бичмэл номонд дурдаад байгаа чиндаруу цагаан гэдэг нь цэцэг буюу бодоо өвчнийг цээрлэн нэрлэсэн нэр харин чиндаруу цагааны хогжруу гэдэг нь цагаан цэцэг буюу бодоо өвчний цэврүүг заасан үг гэдэг нь тодорхой болж байна. Анагаах ухааны хувьд чиндаруу буюу чандрууг нарийвчлан авч үзвэл цагаан цэцгийн цэврүүг авч хатаасны дараах хэлбэрийг хэлж буй хэрэг юм байна. Үүнийгээ Цахар гэвш Лувсанчүлтэм “Тэнгэрийн цагаан цэцэг тарих, эм найруулах ёсон хийгээд татах тэргүүтний бичиг”¹², VIII Богд хааны номын сангаас олдсон “Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” номын хоёрдугаар дэвтрийн төгсгөлийн үгэнд байгаагчлан гиван 7 хувь, жуган 2 хувь, гүргэм 4 хувь, задь, лиш, сүгмэл, гагол дөрөв хувь нижгээд нижгээд хогжруу 9 хувь хэмжсэний дээр адистадтай үрлийг хольж талхлан үйлдээд лам дээд гурав, ер хийгээд ядам номыг тэтгэгч нугууд дор соёрхолыг талбих бөгөөд хөвгүүн дор хамрын нүх зүүн хийгээд хүүхэн дор хамрын нүх баруун дор татуулан орших ану¹³ лам дээдсийн бодоо өвчинд болгох ерөндөг, өнөө цагийн дархлаажуулалтын арга юм.

Цахар гэвшийн боловсруулсан цагаан цэцгийн вакцинаар дархлаажуулах аргын бас нэг онцлог бол салст бүрхүүлийн дархлааг ашиглаж, бодоогийн вирус хүний биед нэвтрэн орох гол замын нэг болох хамрын хөндийн салстыг дархлаажуулах талбар болгон сонгон авсан явдал болно. ЗХУ-ын эрдэмтэд, тухайлбал академич А.А.Сморицинцевээр толгойлуулсан Ленинградын судлаачид томуугийн сулруулсан амьд вакциныг хамарт цацах, татуулах аргыг 1938 оноос боловсруулан туршиж, 1970-1980-аад онд өргөн дархлаажуулалтын түвшинд хэрэглэж байсныг^{14,15} эс тооцвол хамарт цацах, татуулах

аргаар вакцинжуулах арга одоо ч их өргөн дэлгэр хэрэглэгдэхгүй байгаа юм. Харин сүүлийн жилүүдэд хамарт цацах, уулгах зэргээр халдвар орох замыг түшин дархлаажуулах нь хэрэглэхэд хялбар, хамгаалах үр дүн сайтай болох талаар ихээхэн бичих болсон байна.¹⁶

Дүгнэлт

VIII Богд хааны номын сангаас 1924 онд Судар бичгийн хүрээлэнгийн номын санд ирсэн “Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” номын хоёрдугаар дэвтрийн төгсгөлийн үгэнд буй чиндаруу цагаан буюу чандруу цагааныг татах арга нь бодоо өвчнөөс сэргийлэх, хамарт цацаж хэрэглэх, номхотгосон ерөндөг, өнөөгийн ойлголтоор амьд вакцин юм. Энэ аргыг хамгийн оновчтой хувилбарыг Цахар гэвш Лувсанчүлтэм бүтээн өөрийн бэсрэг номондоо бичсэн төдийгүй хожим нь Говь гурван сайхны Шарав маарамба энэ аргыг тарилга болгон хэрэглэж байжээ.

Чиндаруу цагаан, тэнгэрийн цагаан цэцэгт болгодог ерөндөг үнэ цэнээ одоо ч алдаагүй байгаа бөгөөд учир нь бодоогоор өвчилсөн хүний цэврүүний таванд байгаа өндөр хоруу чанартай вирусыг номхотгоход ашигласан эмт бодис бүрийг нэг бүрчилэн нарийвчлан судлах нь вакцин номхотгоход болон дархлаа хүчжүүлэхэд ашиглах өрнийн анагаах ухаанд шинэ, Монголын анагаах ухаанд мартагдсан бодис, технологийг нээн олох үндэс болох боломжтой юм.

Ном зүй

1. Ш.Болд. Анагаах ухааны түүх-1. Боть 2. УБ, 2020, х.20.
2. Ш.Болд, Б.Гэрэлмаа, Б.Жавхлан. Манж анатомийн атлас. УБ, 2022, х.40.
3. О.Самбуу, Э.Ариунаа, Д.Шагдарсүрэн, Б.Гэрэлмаа, Ш.Болд. Исламын анагаах ухааны эртний нэгэн номын судалгаа. Монголын эм зүй, эм судлал сэтгүүл. 2025;1(26): 65-70.
4. Батмөнхийн Тунгалаг. Наймдугаар Богд Жавзандамба хутагтын номын сангийн гар бичмэл номын номзүйн судалгаа. Улаанбаатар, 2011, х. 42-43
5. Нямдаваа П, Болд Ш. Цахар гэвш Лувсанчүлтэм: Бодоогийн эсрэг вакцин анх бүтээсэн Монгол эрдэмтэн оточ. Халдварт Өвчин Судлалын Монголын Сэтгүүл. 2010,

6(37).

6. Лувсансамдүвням. Цахар гэвхийн намтар. Монгол бичгээс хөрвүүлж, удиртгал тайлбар бичсэн Д.Цэрэнсодном, Д.Наранцэцэг. Ариутган шүүсэн Ш.Бира. УБ, 2010.
7. Нямдаваа П, Болд Ш. Цахар гэвш Лувсанчүлтэм: Бодоогийн эсрэг вакцин анх бүтээсэн Монгол эрдэмтэн оточ. Халдварт Өвчин Судлалын Монголын Сэтгүүл. 2010, 6(37), х.56-58.
8. Ш.Болд, Б.Жавхлан нарын “Хүннүгээс Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш нарын цади, бүтээл.” УБ, 2020, х.334.
9. “Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” номын хоёрдугаар дэвтэр. Монгол бичгийн гар бичмэл ном.
10. Нямдаваа П, Болд Ш. Цахар гэвш Лувсанчүлтэм: Бодоогийн эсрэг вакцин анх бүтээсэн Монгол эрдэмтэн оточ. Халдварт Өвчин Судлалын Монголын Сэтгүүл. 2010, 6(37), х.56-58.
11. Ш.Болд, Б.Жавхлан нарын “Хүннүгээс Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш нарын цади, бүтээл.” УБ, 2020, х. 332-335.
12. Цахар гэвш Лувсанчүлтэм “Тэнгэрийн цагаан цэцэг тарих, эм найруулах ёсон хийгээд татах тэргүүтний бичиг”. Модон барын төвөд судар.
13. “Элдэв чухал хэрэгт нууц эмийн жор оршвой” номын хоёрдугаар дэвтэр. Монгол бичгийн гар бичмэл ном.
14. Карпухин, Г.И., Галитаров, С.С. Профилактика гриппа, Ленинград, “Медицина”, 1981, 200.
15. Смородинцев, А.А. Грипп и его профилактика, Ленинград, “Медицина”, 1984, 383.
16. Holmgren, J., Czerkinsky, C. Mucosal immunity and vaccines, Nature Medicine Supplement, 2005, 11(4):S45-53.